

НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА

2017 оны 07 дугаар сарын 05

Тав. Засаглал

5.3. Эрх зүйн орчин, ил тод байдал

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны заалт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага	Шалгуур үзүүлэлт	2017 онд хүрэх түвшин, үр дүн	Шаардлагатай хөрөнгийн хэмжээ / сая төг/ Хөрөнгийн эх үүсвэр	Хэрэгжилтийн хувь
5.3.11. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдүүлж хэвшүүлнэ.	Нийслэлийн хэмжээнд төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэн, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, санхүү төсөв, нягтлан бодох бүртгэлийн сургалтыг үе шаттай зохион байгуулах замаар төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдүүлж ажиллна	НЗДТГ-ын СТСХ, НДАА	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	50%
Тус алба нь Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан 2 ажлын хэсэгт ажиллан, ажлын хэсгийн удирдамжид тусгагдсан холбогдох зорилтуудын хяналт шалгалтын материалуудыг гарган өгч тайланд нэгтгүүлсэн. Мөн Сангийн яамны удирдамжийн дагуу нийслэлийн Нийгмийн халамжийн газар, нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, нийслэлийн Эрүүл мэнд, нийгмийн						

	<p>даатгалын газруудад санхүүгийн хяналт шалгалт хийж, шалгалтын материалуудыг нэгтгэн Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлэн ажилласан.</p> <p>Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудын хүрээнд Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа 70 байгууллага, 9 дүүргийн 484 байгууллага, нийт 555 байгууллагын шилэн дансны 2016 оны 04 дүгээр улирлын тайланг Сангийн яаманд цахимаар хүргүүлсэн. Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын хүрээний 70 байгууллагын мэдээллийг шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд хандан 2016 оны 12 сар, 2017 оны 01, 02 дугаар саруудад хянаж зөрчлийг залруулуулан тайлагнаж ажилласан.</p>					
5.3.12. Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын дотоод хяналтыг сайжруулах замаар ажлын байрны эмх цэгц, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх тогтолцоонд бүрэн шилжүүлнэ.	<p>Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын дотоод хяналтын үйл ажиллагааг үнэлж, холбогдох арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх замаар байгууллагуудын дотоод хяналтын тогтолцоог сайжруулна.</p>	НЗДТГ-ын ХШҮХ, НДАА	<p>Үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөө дээшилсэн байгууллагын тоо</p>	130-аас доошгүй	-	50%
	<p>Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 91 байгууллагын эрсдэлийн үнэлгээг хийсэн. Эрсдэлийн үнэлгээгээр “Их эрсдэлтэй” 23, “Дунд эрсдэлтэй” 57, “Бага эрсдэлтэй” 11 байгууллагад 2017 онд аудит хийхээр төлөвлөсөн.</p> <p>Санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитыг нийт 14 байгууллагад хийж, үнэлэлт дүгнэлт өгөн аудитын зөвлөмжийг хүргүүлсэн.</p> <p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Дотоод аудитын хорооны даргын захиалгаар 2012-2016 онуудад нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийсэн ажлын гүйцэтгэлд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Засаг даргын дэргэдэх агентлаг, харьяа байгууллагуудыг хамруулан гүйцэтгэлийн аудит хийж, дүнг Нийслэлийн Засаг даргад танилцуулсан. Аудитад хамрагдсан байгууллагуудад тайлан зөвлөмжийг хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. 2017 оны 06 сарын 15-ны</p>					

	өдрийн байдлаар нийт 17,661,571.4 (арван долоон тэрбум зургаан зуун жаран нэгэн сая таван зуун далан нэгэн мянга дөрвөн зуу) мянган төгрөгийн зөрчил илрүүлсэн. 2017 оны эхний хагас жилийн байдлаар нийслэлийн төсөвт 23,620,718.0 (хорин гурван сая зургаан зуун хорин мянга долоон зуун арван найм) төгрөгийн орлого төвлөрүүлсэн.			
--	---	--	--	--

ХЯНАСАН: ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

Я.САРАНСҮХ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

Б.СЭРГЭЛЭН